



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

11.16 - 11.20



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт коронавирусын эсрэг вакцинтай холбоотой эерэг мэдээ гарсан ч АНУ-ын ихэнх хэсэгт цар тахлын нөхцөл байдал хүнд байгаатай холбоотой хөрөнгийн зах зээлийн индексүүд холимог үзүүлэлттэй байлаа. Dow Jones Industrial Average, S&P MidCap 400 индекс болон small-cap Russell 2000 индексүүд арилжааны үеэр дээд түвшиндээ хүрсэн ч долоо хоногийн сүүл гэхэд дээд түвшнээсээ буусан байна. Хөрөнгө оруулагчдын цар тахал 2021 онд дуусна гэсэн хүлээлт мөн ОПЕС-ын болон бусад томоохон газрын тос экспортлогч орнууд, олборлолтоо нэмэгдүүлэх төлөвлөгөөгөө хойшлуулсантай холбоотой газрын тосны үнэ нэмэгдэж эрчим хүчний салбарын компаниудын хувьцаа өсөлттэй байлаа. Харин эрүүл мэнд болон ус, цахилгаан, дулааны салбарууд хамгийн их уналттай байлаа.

Европ: Вакцинтай холбоотой эерэг мэдээнээс үүдэн Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд дахин өсөлт үзүүлсэн ч халдварын тоо хурдацтай нэмэгдэж байгаатай холбоотой өсөлтийн хувь бага байлаа. STOXX Europe 600 индекс 1.15%-аар, DAX индекс 0.46%-аар, CAC 40 индекс 2.15%-аар, FTSE MIB индекс 3.84%-аар, FTSE 100 индекс 0.56%-аар тус тус өссөн байна.

Евробүсийн голлох бондуудын өгөөж энэ долоо хоногт бага зэрэг уналттай байлаа. Долоо хоногийн эхэнд вакцинтай холбоотой эерэг мэдээллээс үүдэн хөрөнгө оруулагчид аюулгүй гэж үздэг ХБНГУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ыг их хэмжээгээр зарж эхэлсэн нь өгөөж -0.55%-аас нэмэгдэж -0.52% хүрэхэд нөлөөлжээ. Гэхдээ долоо хоногийн сүүл гэхэд халдварын тоо нэмэгдэж байгаа явдал, Унгар болон Польш улсын Европын эдийн засгийг дэмжих санд тавьсан хориг болон АНУ-ын Сангийн яам царт тахлын хүрээнд хэрэгжүүлж байсан зарим зээлийн хөтөлбөрөө дахин хэрэгжүүлэхгүй болсноос шалтгаалж өгөөжүүд эргэн буурсан байна.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт бага зэрэг өсөлттэй хаагдлаа. Nikkei 225 индекс 142 нэгжээр буюу 0.56%-аар өсөж 25,527.37 нэгж хүрсэн нь энэ оны эхэн үетэй харьцуулахад 7.9%-аар өссөн үзүүлэлт болсон байна. Япон улсын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэдэг large-cap TOPIX болон TOPIX small индексүүд өсөлттэй байлаа.

Өнгөрөгч улирлын Япон улсын эдийн засгийн өсөлтийг жилээр тооцоход 21.4% хүрсэн нь 1968 оноос хойших хамгийн өндөр өсөлт юм. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд хамгийн их нөлөөлсөн хүчин зүйл нь гадаад цэвэр эрэлт нэмэгдсэн буюу дэлхийн автомашины болон дотоодын хувийн хэрэглээний эрэлт сэргэж, импортын хэмжээ буурсантай холбоотой байлаа.

БНХАУ: Энэ долоо хоногт БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд, эдийн засгийн гол үзүүлэлтүүд эерэг гарсантай холбоотой өсөлттэй хаагдлаа. Reuters агентлагийн мэдээлснээр large-cap CSI 300 индекс 1.78%-аар, Shanghai Composite индекс 2.04%-аар тус тус өссөн байна. Бондын зах зээл дээр БНХАУ-аас олон улсад гаргасан 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж 6 функтаар өсөж 3.34% болсон байна. Мөн БНХАУ-ын Ардын Банк дунд хугацааны зээл санхүүжүүлэх замаар 800 тэрбум юанийн санхүүгийн салбарт нийлүүлсэн ба хүүгийн түвшнийг хэвээр үлдээлээ. БНХАУ-ын Ардын Банк мөн санхүүгийн байгууллагуудад олгох дунд хугацааны зээлийн хүүг 2.95% хэвээр хадгалав.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,584.77	0.47% ▲
Dow Jones	АНУ	29,263.48	-0.73% ▼
S&P 500	АНУ	3,557.54	-0.77% ▼
Nasdaq	АНУ	11,854.97	0.22% ▲
S&P/TSX	Канад	17,019.10	2.06% ▲
FTSE 100	Их Британи	6,351.45	0.56% ▲
S&P/ASX 200	Австрали	6,539.20	2.09% ▲
Nikkei 225	Япон	25,527.37	0.56% ▲
Hang Seng	Хонг Конг	26,451.54	1.13% ▲

Бонд	Валют	Купон	Өгөөж
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	3.56%
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	3.29%
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	3.09%
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	1.15%
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	1.06%
DBM' 2023	USD	7.250%	4.80%
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	9.39%
Mongol 2026 (Номад)	USD	5.125%	3.92%

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.150	0.01 ▲
Libor 3M	0.205	-0.02 ▼
Libor 6M	0.249	0.00 ▲
Libor 1YR	0.337	0.00 ▼
US 2YR Bond	0.163	-0.01 ▼
US 3YR Bond	0.213	-0.02 ▼
US 5YR Bond	0.376	-0.03 ▼
US 10YR Bond	0.829	-0.07 ▼

Валютын ханш	2020.11.20	Өөрчлөлт
USD	2,848.94	-0.02% ▼
CNY	433.23	0.62% ▲
EUR	3,378.27	0.34% ▲
RUB	37.60	1.84% ▲
KRW	2.56	0.00%
JPY	27.29	0.63% ▲
CAD	2,184.52	0.78% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,870.99	-0.96% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	24.18	-2.00% ▼
Зэс	USD/lb.	331.00	3.92% ▲
Нүүрс	USD/MT	65.35	4.23% ▲
WTI газрын тос	USD/bbl.	42.15	5.03% ▲
Brent газрын тос	USD/bbl.	44.93	5.03% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.X	2.40%
Бодлогын хүү	2020.X	8.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.X	7.67%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.X	10.65%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.X	3.83%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.X	16.82%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.X	10.47%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 37 компанийн 501.1 сая төгрөгийн 9,867,443 ширхэг хувьцаа арилжаалагдав.


“Талх чихэр” /MSE: TCK/ компанийн хувьцаа 20.54%-аар буюу хамгийн ихээр өсөж 17,020.00 төгрөг хүрч хаагдсан бол “Хөх ган” /MSE: HGN/ компанийн хувьцаа 16.03%-аар буурч 55.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 17.3 сая төгрөгийн 171 ширхэг үнэт цаас арилжаалагдав.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


11-р сарын 20-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,586.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,584.77 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.47%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2020 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	171	17,250,000	100,000	102,500	52	17%

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	518.3	
Зах зээлийн үнэлгээ	2,586,311.0	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,584.77	0.47% ▲
MSE I индекс	8,051.05	0.24% ▲
MSE II индекс	7,358.37	0.00% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Мандал даатгал	2,742,938	136,355,373
Лэндмн ББСБ	596,846	17,553,854
Эрдэнэ ресурс девелопмент корп	14,389	12,229,208
АПУ	20,906	12,229,208
Түмэн шувуут	58,681	9,199,694

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Талх чихэр	17,020.00	20.54% ▲
Мерекс	23.00	15.00% ▲
Тээвэр дархан	9,880.00	14.95% ▲
Улсын их дэлгүүр	1,300.00	8.06% ▲
Айтүүлс	78.00	6.25% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Хөх ган	55.00	-16.03% ▼
Улаанбаатар хивс	18,000.00	-14.69% ▼
Монгол шуудан	600.00	-6.25% ▼
Адуун чулуун	901.00	-5.16% ▼
Монинжбар	85.00	-5.04% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Бумбат-Алтай	284,029,687
Гүүдсек	273,547,701
Ард секюритиз	205,787,194
Апекс Капитал	127,407,915
БиДиСек	39,970,051

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	588.09	625,834.53
Таван толгой	5,780.00	304,404.86
МИК холдинг	11,000.00	227,802.52
Инвекор ББСБ	2,914.00	209,015.15
Говь	190.00	148,221.38

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-нд ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-нд ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-ны ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-нд ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-нд ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-нд ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-нд ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-ны ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-ны ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.08.06-нд ОЛГОВ
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-нд ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХУНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.09.07-нд ОЛГОВ
14	DSS	ДАРХАНСЭЛЭНГИЙНЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-ны ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-нд ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-нд ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-нд ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-ны ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-нд ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-нд ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-нд ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-ны ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-нд ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-нд ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-ны ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-нд ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙДОТОР
35	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	530.2	65.1	12.3%	6.3	2020.09.09	2020.09.28-нд ОЛГОВ
36	APU	АПУ	41,168.2	39,861.6	96.8%	37.5	2020.09.02	2020.11.02-нд ОЛГОВ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

Засгийн газар болон Улсын Онцгой Коммисийн шийдвэрийн дагуу Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотойгоор "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь бүрэн зайнаас ажиллаж, онлайн горимоор арилжааг хэвийн явуулж байгаа болно. Та бүхэн албан тоот, захидлуудыг цахимаар doc@mse.mn хаягт илгээнэ үү.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Цар тахалтай холбоотой авч буй арга хэмжээ, уул уурхайн орлогын тасалдал, улмаар татварын орлого буурсан нь төсвийг хүндрүүлээд байна.

Энэ онд төсвийн алдагдал 4.8 их наяд төгрөг байхаар тодотголоор батлагдсан юм. Ирэх оны хувьд 2.1 их наяд төгрөг байхаар батлаад байна. Засгийн газар нөхцөл байдал өөрчлөгдөж, дотоодод хатуу хөл хорио тогтоосонтой холбоотой ирэх оны төсвийг тодотголын төслийг УИХ-аар хэлэлцүүлэхээр төлөвлөж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTV.mn

МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Дотоодын нийт бүтээгдэхүүн (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2020 оны эхний 9 сард урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 26.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 953.5 (3.5%) тэрбум төгрөгөөр, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 12.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.0 (7.3%) их наяд төгрөгөөр тус тус буурлаа.

ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр)-ий 7.3 хувийн бууралтад уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 595.5 (20.7%) тэрбум төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 401.4 (7.0%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлөв.

Улирлын нөлөөллийг арилган тооцсон, ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 4.4 хувиар өсөв.

ДНБ, 2020 оны эхний 9 сард 7.3 хувиар буурсны (-4.3) пункт нь уул уурхай, олборлолтын салбарт, (-0.6) пункт нь аж үйлдвэр, барилгын салбарт, (-2.9) пункт нь үйлчилгээний салбарт, тухайлбал (-1.5) пункт нь тээвэр, мэдээлэл холбооны салбарт, (-1.5) пункт нь бөөний, жижиглэн худалдааны салбарт, (-1.1) пункт нь бүтээгдэхүүний цэвэр татварт тус тус ногдож байна.

Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 оны эхний 9 сард 2.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар өссөн нь ДНБ-д 1.6 пунктээр зэрэг нөлөөлөв.

Уул уурхай, олборлох салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 оны эхний 9 сард 2.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 20.7 хувиар буурлаа. Энэхүү бууралтад чулуун нүүрс, зэсийн баяжмал, газрын тосны олборлолт буурсан нь голлон нөлөөлжээ.

Аж үйлдвэр (уул уурхай, олборлолтын салбар ороогүйгээр), барилгын салбарын нэмэгдэл өртөг (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 оны эхний 9 сард 1.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар буурч, ДНБ-д 0.6 пунктээр сөрөг нөлөөлөв.

Боловсруулах салбар ДНБ-д 0.4 пунктээр сөрөг нөлөөлөв. Боловсруулах салбарын бууралтад нэхмэлийн үйлдвэрлэл, кокс, шахмал түлш үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэл, химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарууд 38.8-14.2 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Эх сурвалж: Үндэсний Статистийн Хороо

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөнгөн цагааны үнэ сүүлийн 2 жилийн дээд түвшинд хүрч өслөө.

БНХАУ-ын хөнгөн цагааны гарц дээд түвшинд хүрээд байгаа энэ үед Лондоны Металлын биржид үнэ нь сүүлийн хоёр жилийн дээд түвшинд хүрээд байна.

БНХАУ-ын эдийн засаг сэргэж, аж үйлдвэрийн салбарт хөнгөн цагааны эрэлт эрчимтэй нэмэгдэх төлөвтэй байгаа аж. Улмаар ирэх саруудад хөнгөн цагааны хэрэглээг хангалттай дэмжинэ гэж хөрөнгө оруулагчид үзэж байна. Энэ нь БНХАУ-д бүтээн байгуулалт эрчимтэй өрнөж, эрэлт сайн байгаатай холбоотой гэж "Standard Chartered Bank"-ийн шинжээч үзэж байна.

Лхагва гарагт тонн нь 1,998 ам.доллар хүрснээсээ хойш хөнгөн цагааны фьючерс үнэ Лондоны Металлын биржид баасан гарагийн өглөөний байдлаар 1,992.50 ам.доллар болоод байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

Газрын тосны үнэ сүүлийн 2 сарын дээд түвшнээс эргэн буурч эхэллээ

АНУ-д "коронавирус"-ийн халдварын тархалтыг зогсоохын тулд хязгаарлалтуудыг чангатгаснаар сүүлийн хоёр сарын дээд түвшинд хүрээд байсан газрын тосны үнэ унаж эхэллээ. Мөн ОПЕС-ийн Өргөтгөсөн бүлгийн гишүүдийн хооронд маргаан үүсэн нь үүнд нөлөөлөөд байна.

Арабын Нэгдсэн Эмират улс ОПЕС-ийн Өргөтгөсөн бүлгээс гарах талаар дотооддоо зөвшилцөж эхэлсэн талаар мэдээлэл гараад байгаа юм. ОПЕС-ийг газрын тосны гарцын төлөвийг шударга бусаар тогтоосон гэж тус улсын бодлого тодорхойлогчид үзэж байгаатай холбоотой аж. Одоогоор ОПЕС-ийн орнууд газрын тосны гарцаа нэмэгдүүлэх төлөвлөгөөгөө хойшлуулах эсэх асуудлыг хэлэлцэж байна.

Пүрэв гарагийн байдлаар Brent төрлийн газрын тосны үнэ 0.20 хувиар буурч, баррель нь 44.25 ам.доллар болоод байна. Харин WTI-ийн үнэ 0.41 хувиар буурч, баррель нь 41.65 ам.доллар болжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

БНХАУ-ын эрчим хүчний нүүрсний жишиг үнэ 2020 он дуусахаас өмнө тонн нь 630 юань хүрэх төлөвтэй байна.

БНХАУ-ын эрчим хүчний нүүрсний жишиг үнэ он дуусахаас өмнө тонн тутамдаа 630 юань буюу 96 орчим ам.доллар хүрэх төлөвтэй байна. Энэ нь 2019 оны 4-р сараас хойших хамгийн өндөр дүн юм.

Одоогоор Чинхуандаогийн боомт дэх спот ханш 609 юанийн орчим байна. Хэдий тийм боловч үнэ нь маш богино хугацаанд эрчтэй өссөөр байгаа юм.

Эрчим хүчний нүүрсний нийлүүлэлт багасахтай зэрэгцээд цахилгаан эрчим хүчний эрэлт өндөр байгаа нь үүнд нөлөөлж байна гэж "Bloomberg Intelligence"-ийн шинжээчид таамаглалаа. Энэ онд тус улс 2016 оноос хойших хамгийн их хэмжээний нүүрсний хомсдол үүсэх төлөвтэй байгааг БНХАУ-ын Цахилгаан эрчим хүчний зөвлөл анхааруулсан байна.

Уурхайн ослууд ээлж дараалан гарч байгаагийн улмаас БНХАУ хэд хэдэн нүүрсний уурхайгаа хаах, аюулгүй ажиллагааны хяналтаа чангатгах арга хэмжээ авч байна. Энэ нь нүүрсний нийлүүлэлтэд нөлөөлнө гэж шинжээчид үзжээ.

Одоогоор Чинхуандаогийн боомт дэх спот ханш 609 юанийн орчим байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

"COVID-19"-ийн эсрэг вакцины туршилтууд амжилттай болж, алтны үнэ буурч эхлэв

"Коронавирус"-ийн вакцины туршилтууд амжилттай болж, биржээр арилжаалагддаг сангууд алтнаас татгалзаж эхэллээ. Үүнийг дагаад алтны үнэ буурч байна.

Сүүлийн туршилтын дүнгээр "Pfizer"-ийн бүтээж буй "COVID-19"-ийн эсрэг вакцин 95 хувийн үр дүнтэй байгаа талаар мэдээлсэн юм. Нөгөө талаас эдийн засгийг дэмжих нэмэлт төсөв батлах эсэх нь тодорхойгүй болсон байна. Мөн вакцин бэлэн болох хугацаа ойртсоноор наймдугаар сард дээд түвшинд хүрээд байсан алтны үнэ буурч байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.